



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 8/8

Улаанбаатар хот

Г  
Батлан хамгаалах салбарт жөндэрийн  
талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Жөндэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Батлан хамгаалах салбарт жөндэрийн талаар баримтлах бодлого”-ыг хавсралтаар баталсугай.
2. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Батлан хамгаалах яамны дэргэдэх Жөндэрийн орон тооны бус салбар зөвлөл /Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Х.Батбилэг/, Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/, харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын захирал, дарга наарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Д.Ганхуяг/-т үүрэг болгосугай.

САЙД

Н.ЭНХБОЛД



1330100058

Батлан хамгаалахын сайдын 2020 оны  
4 дугаар сарын 18-ны өдрийн  
18.. дугаар тушаалын хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ ЖЕНДЭРИЙН  
ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаас 2011 онд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” хууль, улмаар Засгийн 2017 оны 129 дугаар тогтоолын хавсралтаар “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг тус тус батлагдан, хэрэгжүүлж байна<sup>1</sup>. Эдгээр хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд “Жендэр ба хөгжил” буюу эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээ, тулгамдаж буй асуудлуудыг эн тэнцүү анхаарсан байдаг.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын нийгмийн тогтвортой хөгжлийн нэг зорилт нь “... жендэрийн тэгш байдлыг хангах, ... чиглэгдэнэ” гэж тодорхойлж, улмаар үндсэн зарчмуудад ч “нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялагийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.7-д “Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.”, мөн Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.3.27-д “Жендерийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.”, мөн 5.1.7-д “Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.” гэж тус тус тусгажээ<sup>2</sup>.

Мөн Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.3 в-д “жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байх” гэж заасан.

Монгол Улсын нийт хүн ам 2018 онд 3'238'479 болж, өмнөх онтой харьцуулахад 60580 хүнээр буюу 1.91 хувиар өсчээ. Нийт хүн амыг хүйсээр 2018 оны байдлаар авч үзвэл эрэгтэйчүүд 1 591 848, эмэгтэйчүүд 1 646 631 байна<sup>3</sup>.

Дашрамд дурдахад дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаанаас үзэхэд улс орнуудын хувьд дундаж наслалт хамгийн өндөртэй нь Япон Улс (84.2), хамгийн бага нь Лесото Улс (52.9) байна.

<sup>1</sup> ХНХЯ, ЖҮХ, Азийн хөгжлийн банк. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө (2017-2021)” эмхэтгэл. Улаанбаатар. 2017 он

<sup>2</sup> www.legalinfo.mn

<sup>3</sup> www.1212.mn

Монгол хүний дундаж наслалтыг 1992 онд анх тооцоход 62.7 байсан бол 2018 онд 70.19 болж, энэхүү 26 жилийн хугацаанд 7.4 жилээр уртасчээ. 1992 онд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 64.9, эрэгтэйчүүдийнх 60.7 байсан бол 2018 онд эмэгтэйчүүдийнх 75.8, эрэгтэйчүүдийнх 66.1 болсон байна. Манай улсын хувьд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү 2019 оны байдлаар 9.67 байгаа нь дэлхийн дундажаас бараг 2 дахин их байна<sup>4</sup>.

Эдүгээ Зэвсэгт хүчинд алба хааж буй нийт цэргийн алба хаагчийн 11.7%, энгийн ажилтан, албан хаагчдын 19.7%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна<sup>5</sup>.

Ажлын байран дахь бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх нөхцөл байдал, “Жендерийн эрх тэгш байдлыг хангах” тухай хууль, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, Монгол Улс дахь ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл байдлын судалгаанд хамрагдсан батлан хамгаалах, хууль сахиулах, мэргэжлийн хяналт, боловсролын байгууллагуудаас авсан санал асуулгын дүнгээр ажлын байран дахь бэлгийн дарамтыг хэн нэгэн этгээд үзүүлж байсан гэж 96 хүн буюу 10.43%, 840 хүн буюу 89.57% нь үгүй гэж хариулжээ. Жишээлбэл, батлан хамгаалах салбарын 196 хүнээс “Ажлын байран дахь бэлгийн дарамттай холбоотой үйлдэл, эс үйлдэхүй гарч байсан эсэх” талаар санал асуулга авахад 28 хүн буюу 14.3% нь “тийм”, үлдсэн 168 хүн буюу 85.7% нь “үгүй” гэж хариулжээ<sup>6</sup>.


Дээр дурдсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг батлан хамгаалах салбарт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, цэргийн алба хаагчид, энгийн ажиллагсдад тулгамдаж буй асуудлууд, тэдний ажил, ар гэрийн тэнцвэртэй байдал, гэр бүлийнхний хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдах зэрэг асуудлыг шийдвэрлэх арга зам, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох нь энэхүү бодлогын баримт бичгийг боловсруулах үндэслэл болж байна.

Батлан хамгаалах салбарын жендерийн мэдрэмжтэй  
бодлого, төлөвлөлтийн хүрээ

<sup>4</sup> ЖҮХ. Дэлхийн банк, SIGA XXX. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү, түүнд нөлөөлөх хүчин зүйлс. Сэдэвт судалгааны тайлан. 2019 он

<sup>5</sup> Батлан хамгаалах яамны Ахмадын хороо. “Батлан хамгаалах салбар дахь жендерийн нөхцөл байдлын үнэлгээ. Шифр: Жэндэр” судалгааны ажлын тайлан. 2018 он

<sup>6</sup> Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл. Улаабаатар. 2019



Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн салбарын бодлого нь улс орны, салбарын өмнө тавигдаж буй зорилт, төлөвлөсөн үйл ажиллагааг илүү оновчтой, үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ батлан хамгаалахын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгох, учирч буй саад бэрхшээл, хүндрэлийг арилгах, жендэрийн ялгavarлан гадуурхалт, жендэргээний суурилсан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

### ХОЁР. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

2.1. Энэхүү бодлогын баримт бичгийн зорилго нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг батлан хамгаалах салбарын онцлогтой уялдуулан жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох замаар байгууллагын бүх түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээндээ жендэрийн дүн шинжилгээ хийж, ашиглах чадавхыг бүрдүүлэхэд оршино.

2.2. Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

Зорилт 1. Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх;

Зорилт 2. Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, ашиглах чадавхыг дээшлүүлэх, жендэрийн ялгavarлан гадуурхалт, жендэргээний суурилсан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчинг бий болгох;

Зорилт 3. Жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш байдлыг хангах талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлж, хүний нөөцийг сургаж бэлтгэх.

2.2. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхдээ “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:

- 2.2.1. шинжлэх ухаанчаар хандах;
- 2.2.2. бүх нийтийн идэвх, оролцоонд тулгуурлах;
- 2.2.3. төрийн дэмжлэг, санхүүжилттэй байх.

2.3. Хэрэгжүүлэх хугацаа:

Бодлогын баримт бичгийг 2 үе шаттайгаар 5 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат 2019-2022 он: Батлан хамгаалах салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жөндэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх чадавхыг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёрдугаар үе шат 2023-2024 он: Эхний шатны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, цаашид боловсронгуй болгоход чиглүүлж хэрэгжүүлнэ.

**ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛАЖИЛЛАГАА**

3.1. “Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жөндэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх” нэгдүгээр зорилтын хүрээнд доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. батлан хамгаалах салбарын онцлогтой уялдуулан жөндэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох чиглэлээр бодлогыг тодорхойлж, мэргэжил, арга зүйн удирдамжаар хангах;

3.1.2. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг жөндэрийн мэдрэмжтэй боловсруулах удирдамж аргачлал боловсруулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.1.3. салбарын бодлого, үйл ажиллагаанд оролцоонд суурилсан жөндэрийн үнэлгээ хийх, мэргэжил, арга зүйн удирдамжаар хангах;

3.1.4. Эцэг, эхийн зөвлөл (Эмэгтэйчүүдийн зөвлөл)-тэй хамтран салбарын нийт бие бүрэлдэхүүний хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэн баяжуулах, тэдэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, анги, байгууллагад стандартад нийцсэн өдөр өнжүүлэх байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3.1.5. хүүхэд асрах чөлөөтэй байгаа эмэгтэй алба хаагчдад “Гэр цэцэрлэг хөтөлбөр”-т хамрагдах бололцоог судлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.1.6. олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй эхнэр (нөхөр), байнгын асаргаатай хүүхэд, өндөр настай эцэг, эхээ асардаг, бага орлоготой, өрх толгойлсон цэргийн алба хаагч, ажилтны талаар дэлгэрэнгүй судалгаа гаргаж, тэдний амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн жөндэрийн мэдрэмжтэй төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

3.1.7. эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетийг Цэргийн төв эмнэлэгт нээн ажиллуулах, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжөөр хангах;

3.1.8. “Цэргийн алба хаагчийн гэр бүлийн гишүүнд эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх”<sup>7</sup> журмыг хэрэгжүүлж, Цэргийн төв эмнэлгийн хүүхдийн тасаг, эмэгтэйчүүдийн тусlamж, үйлчилгээний кабинетийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор хүүхэд, эмэгтэйчүүдийн эмчийн орон тоог нэмэгдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх;

3.1.9. Цэргийн төв эмнэлэг болон хугацаат цэргийн алба хаагчтай анги, байгууллагын эмнэлгийн нэгжид нийгмийн эрүүл мэндийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх;

3.1.10. алслагдсан нутагт ажиллаж буй цэргийн алба хаагчийн эхнэр (нөхөр)-ийн нийгмийн идэвхтэй оролцоог хангасан үйл ажиллагааг зохион байгуулах, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх;

3.2. “Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, ашиглах чадавхыг дээшлүүлэх, жендерийн ялгavarлан гадуурхалт, жендерт суурилсан аливаа хүчирхийллээс анgid ажлын орчинг бий болгох” хоёрдугаар зорилтын хүрээнд доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлж, жендерийн эрх тэгш байдлын төлөв байдалд дүн шинжилгээ хийж, үр нөлөөг үнэлж, зөвлөмжийг хэрэгжүүлэх;

3.2.2. хөдөлмөрийн мөлжлөг, хүчирхийлэл, ажлын байран дахь ялгavarлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх, хохирогчийн хүсэлт, гомдлыг ажил олгогчийн зүгээс шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, байгууллагын хөдөлмөрийн харилцааны дотоод журамд тусган, хэрэгжүүлэх;

3.2.3. үндэсний болон бусад улсын сайн туршлагыг судлан нэвтрүүлэх;

3.2.4. салбарт ажиллаж буй нийт бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвхтэй оролцоо, гэр бүлд тулгамдаж буй асуудлуудад суурь судалгаа явуулах, зөвлөмж боловсруулж, хэрэгжүүлэх;

3.2.5. салбарт ажиллаж буй эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, архидан согтуурах, түүнээс улбаалсан хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх;

3.2.6. хүчирхийлэл, ялгavarлан гадуурхахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүнээс анgid байх орчныг бүрдүүлэх чиглэлээр Батлан хамгаалах яамны “Гэмт хэрэг, сахилга, дэг журмаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөл”, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

<sup>7</sup>Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/325 дугаар тушаал

3.2.7. Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд нэгдэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, оролцох, сурталчлан таниулах замаар цэргийн алба хаагч, ажилтан, ажилчдын жендерийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх.

3.3. “Жендерийн хэвшмэл ойлголт, тэгш байдлыг хангах талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлж, хүний нөөцийг сургаж бэлтгэх” гуравдугаар зорилтын хүрээнд доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. жендерийн хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд жендерийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх чадавхыг эзэмшигүүлэх мэргэжил, арга зүйн сургалтад жендер, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнийг хамруулах;

3.3.2. Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Зэвсэгт хүчний анги, байгууллагад явуулж байгаа эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн ялангуяа бэлгийн боловсрол олгох хичээлийн агуулгыг жендерийн өвөрмөц хэрэгцээт онцлогт тохируулан боловсруулж, сургалт зохион байгуулах, сурталчлах;

3.3.3. жендерийн хэвшмэл ойлголт, ажлын байран дахь бэлгийн дарамт, жендерийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, жендерт суурилсан аливаа хүчирхийллээс анgid ажлын орчныг бүрдүүлэх зэрэг асуудлаарх сургалтад гадаад оронд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчдыг заавал хамруулж, хэвшүүлэх;

3.3.4. нийт бие бүрэлдэхүүний дунд бусдыг хүндлэх, хүчирхийлэгч бус байх, гэр бүлийн болон ойр дотны хүнээ хайрлан хүндэтгэх, хүнлэг чанарыг эрхэмлэх, өрх гэрийн үүрэг, хариуцлага, гэр бүлийн харилцаан дахь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог дэмжих, эрүүл амьдралын зан үйлд суралцаж, хорт буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;

3.3.5. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн сонсогч, оюутан, сурагч, хугацаат, гэрээт цэргийн алба хаагчдыг жендерийн хэвшмэл ойлголт, ажлын байран дахь бэлгийн дарамт, жендерийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, жендерт суурилсан аливаа хүчирхийллээс анgid байх зэрэг асуудлаарх сургалтад хамруулж, сурталчлан таниулах;

3.3.6. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн сонсогч, оюутан, сурагч, хугацаат, гэрээт цэргийн алба хаагчдад бусдыг хүндлэх, хүчирхийлэгч бус байх, гэр бүлийн болон ойр дотны хүнээ хайрлан хүндэтгэх, хүнлэг чанарыг эрхэмлэх, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн үүрэг, хариуцлагыг ойлгуулан таниулах, гэр бүлийн харилцаан дахь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог дэмжих чиглэлээр сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

3.3.7. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн сонсогч, оюутан, сурагч, хугацаат, гэрээт цэргийн алба хаагчдад хүний наймаа, бэлгийн мөжлөг, халдварт өвчинд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын зан үйлд

суралцаж, хорт буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааг үе шаттайгаар зохион байгуулах;

3.3.8. Үр хүүхдээ эх оронч үзэлтэй, хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгааг цэргийн алба хаагч, ажилтны гэр бүлийг хамт олны дунд сурталчлах ажлыг зохион байгуулах;

3.3.9. Жендерийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, оролцох.

## ДӨРӨВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

4.1. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.1. цэргийн алба хаагч, ажилтан, ажилчдын жендерийн талаарх хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгднө.

4.1.2. салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төсөлд жендерийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх нөхцөл бүрдэнэ.

4.1.3. салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, ашиглах чадавх дээшилнэ.

4.1.4. жендерийн ялгavarлан гадуурхах, жендерт суурилсан аливаа хүчирхийллээс анgid ажлын орчин бүрдэнэ.

4.1.5. батлан хамгаалах салбарт ажиллаж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш боломж олгох, эрхийг нь хамгаалах механизм бүрдэж, хүний нөөц сургаж бэлтгэгдсэн байна.

## ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТ

5.1. Батлан хамгаалах салбарт жендерийн тэгш байдлыг хангах талаарх дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг Батлан хамгаалах яамны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлөйг удирдах, зөвлөлийн бүрэлдэхүүнийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар байгуулна.

5.2. Батлан хамгаалах яамны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийг Төрийн нарийн бичгийн дарга удирдаж, зөвлөлийн бүрэлдэхүүнийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар байгуулна.

5.3. Батлан хамгаалах яамны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөл нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд тэр нь яамны жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

5.4. Яамны жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь орон тооны бус салбар зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулж, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын жендер, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнийг бодлогын удирдамжаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хамтарч ажиллана.

Хамтын ажиллагаа:

5.5. Жендерийн үндэсний хорооны Ажлын алба, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс болон яамдын Жендерийн салбар зөвлөлүүдтэй хамтран ажиллана.

5.6. Жендерийн тэгш байдлыг хангах талаартөсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэнтэй хамтран ажиллаж болно.

Санхүүжилт:

5.7. Жендерийн эрх тэгш байдлыг хангах хууль, үндэсний хөтөлбөр, салбарын дунд хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ::

5.7.1. улсын төсөв;

5.7.2. хандивлагч улс, орон улсын байгууллагын тусlamжийн хөрөнгө;

5.7.3. Бусад.

#### **ЗУРГАА. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ БА ТАЙЛАГНАЛТ**

6.1. Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа аж ахуйн нэгж, байгууллагууд жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, тухайн оны 06 болон 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Батлан хамгаалах яамны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлд ирүүлнэ.

6.2. Жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хагас болон жилийн тайланг нэгтгэн боловсруулж, Батлан хамгаалах яамны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулна.

6.3. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай” хууль, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагааны явц, хэрэгжилтийн тайлан болон ирэх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Жендерийн үндэсний хорооны Ажлын албандаа оны 01 дүгээр сарын 10-ны дотор хүргүүлнэ.

--- оОо ---